

ИННОВАЦЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ХАРИУЦСАН
АХЛАХ ШИНЖЭЭЧ М.СОЛОНГЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
ЗОРИЛТ 1. ИННОВАЦ, ГАРААНЫ БИЗНЕС, ИХ ӨГӨГДӨЛ, ХИЙМЭЛ ОЮУНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАНА.							
1	Арга хэмжээ 1.1. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Судалгааны тоо	-	1	Тус яамны сайдын 2025 оны А/49 дүгээр тушаалаар “Дроны ашиглалт, хэрэглээний талаар судалж, хууль эрх зүйн орчны судалгаа хийж санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, эхний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Уг хурлаар тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн “Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах” ажлын даалгаврын төслийг танилцуулан, ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг тусган эцэслэж, батлуулсан. Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/98 дугаар тушаалаар байгуулсан. Уг тендер шалгаруулалт эхний удаа амжилтгүй болсон бөгөөд 2025 оны 05 дугаар сарын 29-нд дахин зарлаад байна.	04.01-09.30	50
ЗОРИЛТ 2. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙГ ИННОВАЦ ШИНГЭСЭН ТЕХНОЛОГИОР ХӨГЖҮҮЛЭХ, ИННОВАЦ ШИНГЭСЭН ТЕХНОЛОГИУДЫГ НУТАГШУУЛАХ, ТУРШИХ, ИННОВАЦЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛНА.							

2	Арга хэмжээ 2.1. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж буюу дрон жолоодлогын Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	-	-	Мөн тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/01 дугаар тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан "Дрон жолоодлогын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах" ажлын даалгаврыг боловсруулан, батлуулсан. Тайлант хугацаа болоогүй.	07.10-12.10	-
3	Арга хэмжээ 2.2. Дрон жолоодлогын сургалтын хөтөлбөр боловсруулах, шалгалт баталгаажуулалтын гарын авлага боловсруулна.	Гарын авлагын тоо	-	1	Тус яамны сайдын 2025 оны А/47 дугаар тушаалаар "Сургалтын тогтолцоо бий болгох, зэрэг дэв олгох, санал боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, эхний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Уг хурлаар тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/01 дугаар тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан "Дроны жолоодлогын сургалт хөтөлбөр боловсруулах, шалгалт баталгаажуулалтын гарын авлага боловсруулах" ажлын даалгаврын төслийг танилцуулан, ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн саналыг тусган эцэслэж, батлуулсан. Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/98 дугаар тушаалаар байгуулсан. Уг тендер шалгаруулалтын эхний удаа амжилтгүй болсон бөгөөд 2 дахь удаагийн шалгаруулалтад МУИС-ийн Бизнесийн сургууль шалгарч, 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр гэрээг байгуулсан.	06.02-09.30	60
4	Арга хэмжээ 2.3. Мэдээлэл технологийн Улсын олимпиад зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	-	1	Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Мэдээллийн технологийн улсын олимпиад зохион байгуулах" гүйцэтгэгчийг сонгож, холбогдох тушаал болон гэрээг батлуулан, гэрээний дагуу 2025 оны 04 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд уг олимпиадыг амжилттай зохион байгуулахад оролцож, гэрээ дүгнэх актыг баталгаажуулан, холбогдох санхүүжилт олгогдсон.	03.20-05.30	100

ЗОРИЛТ 3. ХИЙМЭЛ ОЮУН, ИХ ӨГӨГДӨЛ ЗЭРЭГ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД ТУЛГУУРЛАН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ ХУРДАСГАХ, ХИЙМЭЛ ОЮУН УХААНД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛЭХЭД САЛБАР ХООРОНДЫН УЯЛДААГ ХАНГАНА.

5	Арга хэмжээ 3.1. Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	0	1	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төслийг хэлэлцүүлэх анхдугаар чуулганыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг чуулганд гадаадын болон дотоодын илтгэгч, панелист, төр, хувийн хэвшлийн 1000 орчим төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны чиглэлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Түүнчлэн анхдугаар чуулганы үеэр яамны зүгээс танилцуулах стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, танилцуулга болон арга хэмжээний нээлтийн болон хаалтын үгийн хамт бэлтгэсэн.	01.20-02.28	100
ЗОРИЛТ 4. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИНЭ.							
6	Арга хэмжээ 4.1. "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн ажиллах журам"-ын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн журмын тоо	0	1	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.7-д заасны дагуу "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам"-ын төслийг боловсруулан, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралд танилцуулан хэлэлцүүлсэн бөгөөд хурлын шийдвэрээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтсон. Дээрх шийдвэрийн дагуу журмын төслийг Засгийн газрын тогтоолын төсөл, журмын танилцуулгын хамт боловсруулж, ЗГХЭГ, Шадар сайд нар, Засгийн газрын гишүүд болон Үндэсний хороод зэрэг нийт 22 байгууллагад 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1009 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу 19 байгууллагаас ирсэн саналыг нэгтгэн журмын төслийг эцэслэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	03.20-05.30	100
7	Арга хэмжээ 4.2. "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам"-ын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн журмын тоо	0	1	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 13.4-т заасны дагуу "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам"-ын төслийг боловсруулан, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралд танилцуулан хэлэлцүүлсэн бөгөөд хурлын шийдвэрээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтсон. Мөн	03.20-12.10	100

					Дээрх шийдвэрийн дагуу журмын төслийг Засгийн газрын тогтоолын төсөл, журмын танилцуулгын хамт боловсруулж, ЗГХЭГ, Шадар сайд нар, Засгийн газрын гишүүд болон Үндэсний хороод зэрэг нийт 22 байгууллагад 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1009 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу 19 байгууллагаас ирсэн саналыг нэгтгэн журмын төслийг эцэслэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.		
8	Арга хэмжээ 4.3. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн платформ хөгжүүлнэ.	Платформын тоо	0	-	Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/01 дугаар тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн платформыг хөгжүүлэх” ажлын даалгаврыг боловсруулан, батлуулсан. Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/190 дугаар тушаалаар байгуулагдсан.	04.01-12.10	50
9	Арга хэмжээ 4.4. Дроны туршилтын төв байгуулах ажлыг эхлүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	0	30	Тус яамны сайдын 2025 оны А/48 дугаар тушаалаар “Дроны туршилтын бүс байгуулах техник, эдийн засгийн судалгаа хийх, холбогдох хууль тогтоомжийн дагуу туршилтын бүс байгуулах” үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, эхний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Уг хурлаар туршилтын бүс байгуулахтай холбоотой ажлын явцыг танилцуулж, цаашид хийх ажлын талаар санал солилцсон. Мөн Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ-ын санхүүжилтээр хийгдэхээр тусгагдсан “Дроны туршилтын бүсийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” ажлын даалгаврыг боловсруулсан. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас 2025 оны 1/381 албан тоотоор ирүүлсэн байршлуудыг 2025 оны 04 дүгээр сард Харилцаа холбооны зохицуулах хороонд радио давтамжийн харилцан нөлөөллийн хэмжилт дүгнэлт гаргуулсан бөгөөд дээрх 2 байршил нь туршилтын бүс байгуулахад намгархаг, дэд бүтцээс хол байгаа тул дахин байршил сонгох процессыг ГЗБГЗЗГ, ИНЕГ-тай хамтран хэрэгжүүлж байна.	03.20-12.10	50

ЗОРИЛТ 5. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАНА.

10	Арга хэмжээ 5.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнана.	Төлөвлөгөөн ий тоо Тайлангийн тоо	2 1	- 1	Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, батлуулсан. Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар холбогдох хугацаанд нь тайлагнасан.	01.15-12.10	100
11	Арга хэмжээ 5.2. Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ.	Хүргүүлсэн биелэлтийн тоо	-	Тухай бүр	1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичгийн биелэлтийг тухай бүр хариуцсан ажлын чиглэлээр гаргаж, холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. 2. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг бэлтгэж, Инновац, цахим бодлогын байнгын хороонд 2025 оны 4, 5, 6 сард тус тус танилцуулсан. 3. Ерөнхий сайд 2025 оны 01 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд “Дэлхийн эдийн засгийн форум”-д оролцохтой холбогдуулан хиймэл оюун ухааны чиглэлээр мэдээлэл бэлтгэн Ерөнхий сайдын ажлын албанд хүргүүлэв. 4. Их өгөгдөл, хиймэл оюун ухааны чиглэлээр хийсэн, хийгдэж буй болон хийхээр төлөвлөж буй ажлын талаарх мэдээллийг бэлтгэн хүргүүлж, Инновац, цахим бодлогын хороонд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр мэдээлэл хийсэн.	01.15-12.10	100
12	Арга хэмжээ 5.3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ.	Шийдвэрлэсэн албан бичгийн тоо	-	Тухай бүр	Газрын удирдлагаас цохогдсон 41 албан бичгийг шийдвэрлэж, холбогдох хариуг хүргүүлсэн.	01.15-12.10	100
13	Арга хэмжээ 5.4. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг	ХАСХОМ маягтын тоо	-	1 Тухай бүр	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь бөглөсөн.	01.15-12.10	100

	сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.	Ашиг сонирхлын зөрчлийн маягтын тоо					
--	--	-------------------------------------	--	--	--	--	--

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Үүрэг даалгавар 1. Их өгөгдөл, хиймэл оюуны судалгаа хийж, үндэсний стратегийн төсөл боловсруулна.	Судалгааны тоо Боловсруулсан стратегийн төслийн тоо	-	1 1	Их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж, Монгол Улсын хэмжээнд хиймэл оюуныг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар судалж стратегийн төслийг боловсруулахад шаардлагатай суурь судалгааг хийсэн. Дээрх суурь судалгаанд үндэслэн "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийг төслийг 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан, стратегийн төслийн талаарх танилцуулгыг холбогдох арга хэмжээ, хэлэлцүүлгүүдэд зориулан тухай бүр бэлтгэсэн.	02.03-12.10	100
2	Үүрэг даалгавар 2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбараас үзүүлж буй төрийн үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлэн гүйцэтгүүлэх боломжтой үйлчилгээний судалгаа боловсруулна.	Судалгааны тоо	-	1	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбараас үзүүлж буй төрийн үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлэн гүйцэтгүүлэх боломжийн талаар судалгааг хийсэн. Судалгааны хүрээнд хууль эрх зүйн орчныг судалж, салбарын болон харьяа байгууллагаас албан бичиг, цахим шуудангаар санал авч боловсруулалт хийж, СБТГ-т өгсөн.	01.15-03.15	100
3	Үүрэг даалгавар 3. Монгол Улсын богино болон дунд хугацааны хөгжлийн баримт бичигт санал боловсруулна.	Санал өгсөн хуулийн болон санамж бичгийн төслийн тоо	-	2	1. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөнд инновац, гарааны бизнес, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр санал боловсруулж, СБТГ-т өгсөн. Мөн түүнчлэн с хүргүүлсэн саналын хүрээнд ЗГХЭГ-ын холбогдох албан тушаалтнуудтай 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр уулзаж, уулзалтын хүрээнд хүргүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл өгч, харилцан ярилцсаны дүнд саналуудыг засч сайжруулан цахимаар хүргүүлсэн. 2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний төсөлд инновац, хиймэл оюун ухаан,	01.15-12.10	100

					гарааны бизнес зэрэг чиглэлээр оруулах арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн хамт боловсруулан СБТГ-т өгсөн. 3. Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгуулахаар дор дурдсан арга хэмжээний саналыг холбогдох мэдээллийн хамт боловсруулан СБТГ-т өгсөн: - Хиймэл оюуны үндэсний хэмжээний тогтолцоог бүрдүүлж, GPU кластер бүхий төв байгуулах; - Уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, зам, тээвэр, логистик, эрүүл мэнд, хөдөө аж ахуй болон бусад тэргүүлэх салбарт хиймэл оюун, их өгөгдөл зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх 100 туршилтын төслийг үе шаттай хэрэгжүүлэх; - Дэвшилтэт технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх сэндбокс байгуулах; - Мэдээллийн технологийн төрөлжсөн төв байгуулах; - Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн туршилтын бүс байгуулах. 4. Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 02 дугаар албан даалгаврын хүрээнд хиймэл оюун ухаан, өндөр технологи болон ногоон хөгжлийн чиглэлээр тусгуулах арга хэмжээний саналыг холбогдох мэдээллийн хамт боловсруулан СБТГ-т өгсөн. 5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026-2028 оны хөрөнгө оруулалтын төсөлд санал болон 2026 оны төсвийн төсөлд санал боловсруулж, Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтэст өгсөн.			
4	Үүрэг даалгавар 4. тогтоомжийн төсөлд боловсруулж, хүргүүлнэ.	Хууль санал	Санал өгсөн хууль тогтоомжийн төслийн тоо	-	Тухай бүр	1. Зам, тээврийн яамнаас ирүүлсэн Агаарын тээврийг хялбаршуулах журмын төслийг судлан санал боловсруулж, 2025 оны 01/371 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. 2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцан холбогдох саналыг боловсруулж, Хуулийн хэлтэст өгсөн. 3. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдан гарах Шуудангийн	01.15-12.10	100

					тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг судлан, санал боловсруулж, Салбарын эрх зүйн орчны шинэчлэл, хуулийн хэлтэст өгсөн.		
5	Үүрэг даалгавар 5. Олон улсын байгууллагатай хамтран ажиллана.	Санал хүргүүлсэн төслийн тоо	-	Тухай бүр	1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж буй Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хөрөнгө оруулалтын стратеги боловсруулах судалгааны тайлангийн уулзалтыг зохион байгуулж, оролцсон. Уг уулзалтаар тайланг сайжруулахтай холбоотой асуудлын талаар хэлэлцэж, явцын тайланд санал өгсөн. 2. Японы хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай Техникийн хамтын ажиллагааны хүрээнд салбарын хууль эрх зүйн орчинг сайжруулах, хүний нөөцийн бодлого боловсруулах, гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэх, их өгөгдлийг бий болгох чиглэлүүдээр хамтран ажиллахаар салбарын өнөөгийн байдал, хийх ажлын талаарх мэдээллийг хүсэлтийн хамт боловсруулан, тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулан ЖАЙКА-д хүргүүлсэн. 3. Нэгдсэн үндэстний байгууллагаас ирүүлсэн Үндэсний өгөгдлийн засаглалын тайлантай танилцаж, санал боловсруулан газрын даргад танилцуулсан. 4. Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн гүйцэтгэсэн Үндэсний блокчейн хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх бэлэн байдлын үнэлгээний тайлантай танилцаж, санал боловсруулан газрын даргад танилцуулж хүргүүлсэн.	01.15-12.10	100
6	Үүрэг даалгавар 6. Дэвшилтэт технологийн хөгжүүлэх сэндбокс журмын төсөл боловсруулна.	Боловсруулсан журмын төслийн тоо	-	1	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн дэмжих тухай хуулийн дагуу "Хиймэл оюун, их өгөгдөл, блокчэйн, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбокс орчны зохицуулалтын журам"-ын төслийг эхний байдлаар боловсруулсан.	04.07-12.10	100
7	Үүрэг даалгавар 7. Төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын комисст ажиллана.	Гүйцэтгэлийн хувь	-	100	Төрийн албаны зөвлөлийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан шалгалтын комиссын бүрэлдэхүүнд тус газрын ахлах шинжээч М.Солонго ажиллаж, 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр төрийн	04.28-05.09	100

					жинхэнэ албаны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын комисст орж ажилласан.		
--	--	--	--	--	---	--	--


ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд оролцох	Тухай бүр холбогдох хурал, зөвлөгөөнд хамрагдсан байна.	-	Тухай бүр	1. Гадаад харилцааны яамнаас зохион байгуулсан “Дижитал худалдааны 7 хоног” арга хэмжээнд 2025 оны 3 дугаар сарын 25-наас 28-ны өдрүүдэд тус газрын ахлах шинжээч М.Солонго оролцсон. Уг арга хэмжээний үеэр Монгол Улсын дижитал худалдааг хөгжүүлэх шаардлага, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцохоос гадна Хил дамнасан цаасгүй худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтийг хэрхэн хангах талаарх зөвлөмжийн талаар ярилцсан. 2. Инженер геодези ХХК-иас 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулсан “DJI WORKSHOP 2025” арга хэмжээнд оролцож, дроны сүүлийн үеийн загварууд болон төр, хувийн хэвшлийн зүгээс хэрэгжүүлсэн арга хэмжээ, судалгааны үр дүнгийн талаар мэдээлэл авсан. 3. Гаалийн ерөнхий газраас 2025 оны 5 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан “Хиймэл оюунд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлж, Монголын гаалийн шинэчлэлийг бэхжүүлэх төсөл”-ийн уулзалтад оролцож, гаалийн байгууллагын өнөөгийн байдал, уг төслийн хүрээнд хийгдэх ажлын талаар мэдээлэл авсан. 4. Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын Хуульчдын холбоо, Олон Улсын Улаанбаатарын их сургуулийн Хууль зүйн сургууль, Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгээс 2025 оны 05 сарын 14-ний өдөр зохион байгуулсан “Хиймэл оюун ба эрх зүйн тогтолцоо” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцож, хууль сахиулах салбарт хиймэл оюунд тулгуурлан хэрэгжүүлж буй төсөл болон БНСУ-ын	01.15-12.12	100

					хиймэл оюуны хуулийн талаар мэдээлэл авч, туршлага судалсан.		
2.	Арга хэмжээ 2. Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан сургалт, семинарт оролцох	Тухай бүр холбогдох сургалт, семинарт хамрагдсан байна.	-	Тухай бүр	Шинжлэх ухааны академиас 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан "Нээлттэй өгөгдөл ба судалгааны их өгөгдөл" сургалт, хэлэлцүүлэгт оролцсон. Уг арга хэмжээний хүрээнд их өгөгдөлд баримтлах зарчим болон их өгөгдлийг бий болгоход дата бэлэн байгаа эсэх талаар санал солилцсон.	01.15-12.12	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Мэдээллийн технологийн үйлдвэрлэл
хариуцсан ахлах шинжээч
(Албан тушаал)

М.Солонго /  /
(Нэр, гарын үсэг)

 / 06 / 06
(Огноо)